



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах,  
хугацаа сунгах тухай

“Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлаар санал боловсруулах зөвлөл”-ийн 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Цагаанбанди овогтой Буянбаатарыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар АНУ-ын Вирджиния Олон улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Лхагва овогтой Билгүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар Англи улсын Сассексийн их сургуулийн магистрантурт жендер судлалын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Гантөмөр овогтой Эрдэнэбаатарыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар ОХУ-ын Дотоод хэргийн яамны харъяа Удирдлагын академийн докторантурт 3 жилийн хугацаагаар, Самдан овогтой Жаргалсайхан, Ваанчиг овогтой Чулуунбат, Сүрэнбаа овогтой Бямбадорж, Донров овогтой Цогтбаатар нарыг Тагнуулын ерөнхий газрын захиалгаар ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны академийн докторантурт 2 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Мэндбаяр овогтой Анууг Англи улсын Оксфорд Брүүкс их сургуульд 1 жилийн хугацаагаар, Ганбаатар овогтой Энхтүвшинг Япон Улсын Тэйкё их сургуульд эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Амарсанаа овогтой Ууганбаярыг БНСУ-ын Чёнжү их сургуульд мэдээллийн технологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Мидэр овогтой Эрдэнэбаярыг ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрх зүйн их сургуульд банк, санхүүгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Нэргүй овогтой Гантулгыг БНТУ-ын Анкара хотын METU Техникийн их сургуульд барилгын инженерийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Жаргалсайхан овогтой Ариунсайханыг Япон Улсын Ази Номхон Далайн их сургуульд экологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Наранбат овогтой Урандарийг АНУ-ын Вирджиния мужийн Монтгомери коллежид эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

3. АНУ-ын Колорадогийн их сургуулийн докторантурт барилгын инженерийн чиглэлээр суралцаж буй Содномцэрэн овогтой Баясгалангийн суралцах хугацааг 1 жилээр сунгасугай.

4. ОХУ-ын Москвагийн Хэрэглээний биотехнологийн улсын их сургуулийн докторантурт суралцаж буй Чулуунбат овогтой Цэнд-Аюуш, ОХУ-ын Москвагийн Хэл шинжлэлийн их сургуулийн аспирантурт суралцаж буй Тогтох овогтой Мөнхтуяа, ОХУ-ын Дотоод хэргийн яамны харъяа Санкт-Петербургийн их сургуулийн докторантурт суралцаж буй Ойдов овогтой Цэцэгмаа, Галбат овогтой Гантөмөр нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-г тус тус даалгасугай.



*Баясгалан*

Н.БОЛОРМАА